

# ГАДААДАД ТОМИЛОЛТООР АЖИЛЛАСАН ТАЙЛАН

2024 оны 07 дугаар сарын 08

Улаанбаатар хот

“DT Aviation Service” компанид Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт эд анги шилжүүлэх гэрчилгээ олгох баримт бичгийн хяналт шалгалт гүйцэтгэсэн тухай

## **1. Зорилго:**

“МИАТ” ТӨХК-ийн 2024 оны 06 дугаар сарын 13-ний өдрийн 02/1590 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу гэрчилгээ олгох баримт бичигт үзлэг шалгалт хийж гүйцэтгэсэн.

## **2. Хяналт шалгалт явуулах эрх зүйн үндэслэл:**

Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтыг тус тус үндэслэн дараах дүрмүүдийн хүрээнд үзлэг шалгалтыг гүйцэтгэнэ. Үүнд:

- ИНД-145“Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт”

## **3. Хяналт шалгалт гүйцэтгэх бүрэлдэхүүн:**

Ж.БАДРАЛ

Нислэгт тэнцэх чадварын хэлтсийн инженеринг хариуцсан нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч

## **4. Хяналт шалгалт гүйцэтгэх хугацаа:**

Бүгд Найрамдах Хятад Ард Улс, 2024 оны 07 дүгээр сарын 01-ны өдрөөс 07 дугаар сарын 05-ны өдрүүдэд үзлэг шалгалт гүйцэтгэсэн.

## **5. Хяналт шалгалтаар гүйцэтгэсэн ажил:**

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын “DT Aviation Service” компанид Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт эд анги шилжүүлэх мэдэгдэл олгох үзлэг шалгалтын ажлуудыг ИНД-145, ИНД-100-ын холбогдох шаардлагууд болон Нислэгт тэнцэх чадварын хэлтсийн үйл ажиллагааны зааврын 5.2.5.1-д заасны дагуу “MCAA/SSC-AW-ORG-3. Checklist for the Certificate of Maintenance organization certification” шалгах хуудсаар дараах чиглэлээр гүйцэтгэсэн. Үүнд:

- Ажилтанд тавих шаардлага – ИНД-145.51;
- Байгууламжийн шаардлага – ИНД-145.53;
- Төхөөрөмж, багаж хэрэгсэл болон материал – ИНД-145.55;
- Бүртгэл хөтлөх – ИНД-145.63;

- Шилжүүлэх мэдэгдэл гаргах зэрэглэл – ИНД-145.68;
- (а) Хэрэв хүсэлт гаргагч нь 145.11(а),(13),(14) болон (15)-д дурдсан S1, S2, эсхүл S3 зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэхийг зорьж байгаа бол дараах шаардлагыг хангах үүрэгтэй:
  - (1) дараах үйл ажиллагаа хариуцсан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтны багийг томилох:
    - (i) нисэхийн бүтээгдэхүүнийг хүлээн авах;
    - (ii) үзлэг шалгалт болон тест хийх;
    - (iii) нисэхийн бүтээгдэхүүнийг илгээх болон шилжүүлэх мэдэгдэл гаргах;
  - (2) хангамжийн бүх ажиллагаанд тохирох дараах барилга байгууламжаар хангах:
    - (i) хангамжийн ажиллагааг удирдан зохион байгуулах захиргааны байр;
    - (ii) үзлэг шалгалт болон тест хийх байгууламж;
    - (iii) хүлээн авах болон илгээх байгууламж;
    - (iv) агуулахын байгууламж;
  - (3) дараах мэдээллийг багтаасан, шилжүүлэх мэдэгдэл гаргах хангамжийн хяналтын журмыг тогтоох:
    - (i) шилжүүлэх мэдэгдэл гаргаж байгаа хангамжийн байгууллагын нэр болон гэрчилгээний зөвшөөрлийн дугаар;
    - (ii) гаргасан огноо;
    - (iii) нисэхийн бүтээгдэхүүнийг тодорхойлолтоор нь, хамааралтай бол эд анги, зураг, тодорхойлолт, серийн болон багцын дугаараар нь таньж тогтоох;
    - (iv) хадгалах хугацаа болон нийт хугацааг багтаасан, нисэхийн бүтээгдэхүүний ашиглалттай холбоотой хязгаарлалт болон тохирол;
    - (v) агуулагдсан тоо хэмжээ;
    - (vi) үйлдвэрлэлийн явцад хийсэн модификацийн дэлгэрэнгүй мэдээлэл;
  - (4) бүртгэл хөтлөх дараах журмыг тогтоох:
    - (i) үнэн зөв, гаргацтай, бөгөөд байнгын, арилдаггүй байдалтай байх;
    - (ii) тухайн мэдээллийг оруулснаас хойш 7 жил хадгалдаг байх.

#### **6. Хяналт шалгалтын тайлан, авах арга хэмжээ:**

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын “DT Aviation Service” компанийн үйл ажиллагааны заавар, хамтрагч байгууллагатай хийсэн гэрээ, үндсэн эд материалын даатгал, үйл ажиллагааний цар хүрээ зэрэг бичиг баримтыг ИНД-145-ын шаардлагуудын дагуу 2024 оны 07 дүгээр сарын 02-ны өдрөөс 07 дугаар сарын 04-ны өдрүүдэд үзлэг шалгалт гүйцэтгэсэн.

ТАНИЛЦСАН:

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА


  
Г.БАТБАЯР

ХЯНАСАН:

НИСЛЭГТ ТЭНЦЭХ ЧАДВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТЫН АХЛАХ БАЙЦААГЧ

  
Г.ГАНХУЯГ

БОЛОВСРУУЛСАН:  
НИСЛЭГТ ТЭНЦЭХ ЧАДВАРЫН ХЭЛТСИЙН ИНЖЕНЕРИНГ ХАРИУЦСАН  
НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЯЛТНЫ БАЙЦААГЧИ

 Ж.БАДРАЛ